



НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 1/01

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний
чиглэлийн замналд зогсоол нэмэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар баталсан “Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм”-ийн 4.1.2.1, 4.1.2.2, 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:24Б “Нисэх – ТЭЦ-4 – 3, 4-р хороолол - Гандан” чиглэлийн замналд “Ирээдүй хотхон” (урд), “Ирээдүй хотхон” (хойд) зогсоолыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх чиглэлүүдийн өөрчлөлтийг программ хангамжид оруулж, нэгдсэн даалгаварт тусган үйлчилгээг 2026 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлүүлэхийг Тээврийн бодлого, судалгааны хэлтэс (Д.Баясгалан)-т, тухайн чиглэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Зорчигч тээврийн хэлтэс (Х.Баасансүрэн)-т, ажлын гүйцэтгэлийг үндэслэн холбогдох санхүүжилтийг тооцож ажиллахыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Б.Бадамдорж)-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Мягмар)-т, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/71 дүгээр тушаалын 01 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ




Нийтийн тээврийн газрын даргын даргын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/01 дүгээр тушаалын хавсралт

Ч:24Б “НИСЭХ - ТЭЦ 4 – 3,4-Р ХОРООЛОЛ – ГАНДАН”



Нийтийн Тээврийн
Бодлогын Газар



Тайлбар :

Эргэлтийн урт:	35 км	Нисэх	Эцсийн зогсоол	Газрын налуугийн градус /уруу/
Эргэлтийн хугацаа:	119 мин	11-р байр	Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол	Газрын налуугийн градус /өгсүүр/
Зогсох буудлын тоо:	58	Сентоза	Нэг чиглэлдээ зогсдог зогсоол	Гэрлэн дохио
Дайран өнгөрөх уулзварын тоо:	10	Хөдөлгөөний чиглэл	Гудамжны нэр	Гүүр
		Эхтэйлгээний өргөн чөлөө		Аюулгүйн тойрог